



АНХААРУУЛГА ЗӨВЛӨМЖ

СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААГ ХЭРХЭН НЭВТРҮҮЛЭХ ТАЛААР

РАДИО, ТЕЛЕВИЗИЙН НИЙТ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДЭД

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.22, Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 9-р сарын 10-ны өдрийн 202 тоот тогтоолын хавсралтаар баталсан “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих журам”-д заасан чиг үүргийн хүрээнд радио, телевизээр нэвтрүүлж буй сонгуулийн сурталчилгаанд хяналт тавьж ажиллана.

Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг хэрхэн нэвтрүүлэх талаар дараах зөвлөмж, анхааруулгыг хүргүүлж байна. Үүнд:

1. **Зөвхөн сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх бүхий радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх.** (Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхээр бүртгүүлсэн);
2. Сонгуулийн сурталчилгаа албан ёсоор эхлээгүй байхад сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх аливаа төлбөртэй, захиалгатай нэвтрүүлэг түгээхгүй байх, сурталчилгааны шинжтэй, маргаан үүсгэх магадлалтай ил, далд хэлбэрийн сурталчилгаа, нэвтрүүлэг нэвтрүүлэхгүй байхад анхаарах;
3. Сонгуулийн сурталчилгааг хуульд заасны дагуу нэр дэвшигчдэд үнэмлэх олгосон өдрөөс буюу **2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлүүлж**, санал авах өдрөөс 24 цагийн өмнө буюу **2024 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 23:59:59 цагаас өмнө зогсоох** (Хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэг);
4. Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхдээ хуульд заасны дагуу **эх сурвалж, нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг** телевизийн хувьд нийт нэвтрүүлгийн туршид, радиогийн хувьд нэвтрүүлгийн эхлэл, төгсгөлд дурдах байдлаар тодорхой илэрхийлэх. (Хуулийн 38.4);
5. Сонгуулийн сурталчилгааг **хоногт 60 минутаас хэтрүүлэхгүй байх** (Хуулийн 45.6);
6. Нэг нам, эвсэлд, түүнчлэн бие даан нэр дэвшигчдэд ногдох хоногт гарах 15 минутыг хэтрүүлэхгүй байх (Хуулийн 45.7);

7. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулиар радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих чиг үүрэг, зохицуулалтын харилцаа нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар хүлээлгэж байсан үүрэг, хариуцлагатай адил зарчимтай байгаа хэдий ч дараах 2 хэсэгт дурдсан **ялгаатай зохицуулалт байгааг анхаарч ажиллана уу.**
- Радио, телевизийн мэдээллийн хөтөлбөрөөр өөрийн редакцын бэлтгэсэн, нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар гаргасан мэдээг хоногт 5 минутаас хэтрүүлэхгүй байх. / нэг нам, эвсэл, тухайн нам, эвслээс нэр дэвшигчийн талаарх мэдээ **нийлээд** хоногт 5 минутаас хэтрэхгүй байх/. (Хуулийн 45.14);
 - **Нэр дэвшигч** сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс хойш санал авах ажиллагаа дуустал сонгуулийн сурталчилгааны бус бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, ярилцлагад орохыг, түүнчлэн сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө хийгдсэн аливаа нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, **дүрс бичлэг**, ярилцлагыг нэвтрүүлэх, нийтлэхгүй байхыг (хуулийн 47.10) тус тус анхаарна уу.
8. Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн радио, телевизүүд **сурталчилгаа нэвтрүүлсэн тухай тайлангаа** олон нийтэд мэдээлснээс хойш (сонгуулийн сурталчилгаа дууссанаас хойш 10 хоногийн дотор) **ажлын 5 хоногт багтаан** (2024.10.25-ны дотор) **Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт маягтын дагуу** албан бичгээр хүргүүлэхийг зөвлөж байна.

Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхээр бүртгүүлээгүй, сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх бүхий бус радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн анхааралд:

Сурталчилгаа нэвтрүүлэх эрхгүй радио, телевиз нь өөрийн хөтөлбөрт сонгуулийн сурталчилгаа болон хууль бус сурталчилгаанд хамаарах аливаа нэвтрүүлэг, сурталчилгаа, дуу, дүрс бичлэг орсон эсэхийг редакциядаа хяналт тавьж ажиллахыг зөвлөж байна.

Хэрэв мэдээллийн хөтөлбөрөөр нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар өөрийн редакцияд бэлтгэсэн мэдээ нэвтрүүлэх, мэтгэлцээний нэвтрүүлэг бэлтгэн хүргэхээр төлөвлөж байгаа бол Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.14, 45.17 дахь заалтыг баримтлан нэвтрүүлэх шаардлагатай. Түүнчлэн тус хуулийн 47 дугаар зүйлд заасан хууль бус сурталчилгаа нэвтрүүлэхгүй байхыг анхааруулж байна.

Мөн дээрх хуулийн 45 дугаар зүйлийн 45.15 дахь хэсэгт заасны дагуу сонгогчдын боловсролд зориулсан мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг, хөтөлбөр бэлтгэж түгээх үүрэгтэй болно.

**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

2024.09.18